

**ШИВЭЭГОВЬ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН
2019 ОНЫ АВЛИГЫН ЭСРЭГ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ЖИЛИЙН ЭЦСИЙН БИЕЛЭЛТ**

2019.11.25.

д/д	Зорилт	Хэрэгжүүлэх арга хэмжээ	Хугацаа	Биелэлт	Хувь
Авлигын эсрэг хууль тогтоомжийг хэрэгжүүлэх, авлигаас урьдчилан сэргийлэх, шударга ёс, ил тод байдлыг хангах чиглэлээр:					
1	Авлигын эсрэг хууль тогтоомжийг иргэдэд сурталчлах, энэ талаарх мэдээллийг иргэд байгууллага чөлөөтэй авах нөхцлийг бүрдүүлэх	Авлигын эсрэг хууль тогтоомж, гарын авлагыг иргэдэд сурталчлах, бүх төрлийн арга хэлбэрийг ашиглан мэдээллийн хүртээмжийг нэмэгдүүлэх	Жилдээ	Авлигын эсрэг хуулиар гарын авлага бэлтгэн багийн иргэдийн нийтийн хуралд ирсэн 80 гаруй иргэд болон төрийн албан хаагчдад олгож ажилласан. Мөн авлигын эсрэг зурагт хуудсуудыг мэдээллийн самбарт байршуулан ажилласан. Мөн авлигатай тэмцэх газраас зохион байгуулсан сургалтанд төрийн захиргааны 15 албан хаагчийг хамруулсан.	100
2		Засаг даргын тамгын газрын “Авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөө”-г вэб сайт болон мэдээллийн самбарт байршуулах	Жилдээ байнга	Засаг даргын тамгын газрын “Авлигын эсрэг” төлөвлөгөөг 5 зорилтын хүрээнд 17 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөн батлуулж төлөвлөгөөг сумын shiveegovi.gs.gov.mn сайт, мэдээллийн самбарт байршуулан ажилласан.	100
3	Хөрөнгө орлогын мэдүүлгийг бүртгэх, хадгалах, мэдээлэх, хяналт тавих ажлыг хуулийн дагуу зохион байгуулах	Хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлэг, мэдэгдэл, хувийн ашиг сонирхол, хөрөнгө орлогын мэдүүлгийг хуулийн хугацаанд гаргах	Жилдээ хуулийн хугацаанд	ХАСХОМ гаргадаг 4 албан хаагчийн мэдүүлгийг хугацаанд нь баталгаажуулж ХАСХОМ-1,2,3,4 мэдээ, тайланг хугацаанд нь гаргаж аймгийн Хууль эрх зүйн хэлтэст хүргүүлэн ажилласан. Мөн 2019 онд шинээр 2 албан хаагчийн урьдчилсан мэдүүлэг, 4 үнэлгээний хорооны мэдэгдэл тайлбарыг	100

				программид шивсэн.	
4		ЭБАТ хариуцсан мэргэжилтэнг чадавхжуулах сургалтанд хамруулах ажлыг зохион байгуулах	1-р улиралд	Авлитатай тэмцэх газраас 21 аймаг 330 сумын ЭБА-уудад зохион байгуулсан сургалтанд ЗДТГ-ын ЭБА-г 2019 оны 02 дугаар сард хамруулсан.	100
Төсвийн ил тод байдлыг хангах чиглэлээр:					
5	Төсвийн ил тод байдлыг хангаж, төсвийн орлого, түүний зарцуулалт, хуваарилалтыг олон нийтэд тухай бүр мэдээлэх, Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг хангах	Шилэн дансны тухай хуулийн дагуу төсөв, санхүүгийн үйл ажиллагаатай холбоотой мэдээллийг хуулийн хугацаанд мэдээлэх	Жилдээ	Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг хангах зорилгоор 2019 онд хийж гүйцэтгэх 30 арга хэмжээг төлөвлөн Засаг даргаар батлуулан хэрэгжилтийг ханган ажиллаж байна. Төлөвлөгөөний дагуу төсвийн бүх байгууллагуудын төсвийн гүйцэтгэлийн сар, улирлын мэдээг хуулийн хугацаанд байршуулж хэвшсэн.	100
6	Тухай бүр мэдээлэх, Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг хангах	Хагас жил, жилийн эцсийн санхүүгийн тайланг цахим хуудас болон мэдээллийн самбарт байршуулсан байх	Жилдээ хуулийн хугацаанд	2019 оны хагас жилийн санхүүгийн тайланг цахим хуудас болон мэдээллийн самбарт байршуулсан.	70
7	Тухай бүр мэдээлэх, Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг хангах	Тухайн жилийн төсөвт орсон өөрчлөлт, төсвийн хэмнэлт, хэтрэлт, түүний шалтгааны тайлбарыг улирал бүр цахим хуудас болон мэдээллийн самбараар мэдээлэх	Жилдээ Тухай бүр	Төсвийн хэтрэлт хэмнэлтийн мэдээг санхүүгийн мэдээллийн самбарт сар бүрийн 10-ны дотор, цахим болон шилэн дансанд сар бүрийн 8-ны дотор байршуулан ажилласан.	100
8	Зөвшөөрөл, бүртгэлийн үйл ажиллагааны ил тод, нээлттэй байдлын хангах	Тусгай зөвшөөрлийн хэрэгжилтийн талаар цахим хуудас болон мэдээллийн самбарт иргэдэд харагдахуйц байдлаар байршуулах.	1-р улиралд	Тамхины тусгай зөвшөөрөл авах, сунгахад бүрдүүлэх баримт бичгийн талаарх мэдээллийг сумын вэб сайтад байршуулсан.	100
9	Зөвшөөрөл, бүртгэлийн үйл ажиллагааны ил тод, нээлттэй байдлын хангах	Тусгай зөвшөөрөл эзэмшигчийн нэр, хаяг, эрхлэх үйл ажиллагааны чиглэл, зөвшөөрөл олгосон болон дуусгавар болох хугацааг цахим хуудсанд айлгомжтой байдлаар байршуулах	жилдээ	Суманд тамхины тусгай зөвшөөрөлтэй 1 аж ахуйн нэгж 4 иргэн үйл ажиллагаагаа явуулж байна. Эдгээр иргэдийн мэдээллийг сумын вэб сайтад байршуулан иргэдэд ил тод мэдээллэн ажиллаж байна.	100

Хүний нөөцийн ил тод байдлыг хангах чиглэлээр					
10	Хүний нөөцийн ил тод байдлыг хангах	Ажлын байрны сул орон тооны зарыг нийтэд зарлах, цахим болон мэдээллийн самбарт байршуулах	Жилдээ тухай бүр	Төрийн үйлчилгээний болон гэрээт албан хаагчдын сул орон тооны зарыг цахим болон мэдээллийн самбарт байршуулан ажилласан.	100
11		Аймгийн ТАЗСЗ-д сул орон тооны захиалга хүргүүлж зарлуулах	Жилдээ тухай бүр	Төрийн захиргааны 3 сул орон тооны захиалгыг 9-р сард аймгийн төрийн албаны зөвлөлд хүргүүлсэн.	100
12		Сул орон тоог хэрхэн нөхсөн талаар мэдээллийг цахим болон мэдээллийн самбарт байршуулах	тухай бүр	2019 онд ЗДТГ-т төрийн захиргааны 5 сул орон тоо гарсаны нэгийг Дундговь аймагт ажиллаж байсан ХААТ-ын мэргэжилтэнг шилжүүлэн томилсон. Мөн ЗДТГ-ын даргын үүргийг түр орлон гүйцэтгэгчээр Баянхонгор аймагт ажиллаж байсан мэргэжилтэнг шилжүүлэн томилсон. Сул орон тоог нөхсөн талаарх мэдээллийг сумын вэб сайтад байршуулсан.	100
Худалдан авах ажиллагааны ил тод байдлыг хангах чиглэлээр					
13	Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах ажиллагааны ил тод	Тендерийн баримт бичиг, тендер шалгаруулалтыг явуулах журам, тендерийн урилга, шалгуур үзүүлэлт, тендерт шалгарсан болон шалгараагүй оролцогчийн талаарх мэдээлэл, шалгарсан болон шалгарч чадаагүй үндэслэл шалтгааны талаарх мэдээллийг /7 хоногийн дотор/ хуулийн хугацаанд нийтэд мэдээлэх	Жилдээ тухай бүр	Сумын ОНХС-ийн 99,8 сая төгрөгийн хөрөнгөөр 4 ажлын тендерийг худалдан авах ажиллагааны журмын дагуу цахимаар зарлаж, дүгнэсэн. Уламжлалтаар зарлагдсан тендер байхгүй болно. Тендертэй холбоотой мэдээллийг сумын цахим хуудас болон www.tender.gov.mn-ээр иргэдэд мэдээлэн ажилласан.	100
14		Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажлыг нийтэд ил тод, нээлттэй зохион байгуулах	Жилдээ тухай бүр	2019 оны худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, тендерийн урилгыг үндэсний “Монголын үнэн” сонинд нийтэлж www.tender.gov.mn , www.mof.gov.mn , www.shiveegovi.gs.gov.mn цахим хуудаст байршуулж мэдээлсэн. Мөн ОНХС-ийн хөрөнгө зарцуулалтын мэдээг сар бүр шилэн данс, цахим	100

				худалдан авах ажиллагааны www.tender.mn сайт, сумын цахим сайтад тухай бүр байршуулж, ЗДТГ-ын хөрөнгө оруулалтын мэдээллийн самбаруудаар байршуулан иргэдэд ил тод мэдээлэн ажилласан.	
15		Худалдан авах ажиллагаанд хийсэн аудитын тайлан, дүгнэлт болон бусад хяналт шалгалтын дүнгийн талаарх мэдээллийг цахим хуудас болон мэдээллийн самбарт хуулийн хугацаанд мэдээлэх	Жилдээ тухай бүр	Сумын 2019 оны худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг Tender.gov.mn , shiveegovi.gov.mn цахим хуудаст байршуулсан. Мөн 2018 оны санхүүгийн тайланд хийсэн санхүүгийн аудит, үйл ажиллагааны аудит, нийцлийн аудитын дүгнэлтүүдийг сумын сайт болон мэдээллийн самбарт байршуулан иргэдэд ил тод мэдээллэн ажилласан.	100
Иргэдийн өргөдөл, гомдол, санал хүсэлтийн шийдвэрлэлт, ил тод байдлын талаар					
16	Иргэдийн өргөдөл, гомдлыг хүлээн авах, шийдвэрлэх, хариу өгөх үйл ажиллагааг боловсронгуй болгох	Өргөдөл, гомдлыг хүлээн авч шуурхай шийдвэрлэх ажиллагааг боловсронгуй болгох арга хэмжээг авч ажиллах	жилдээ	2019 оны 10 дугаар сарын байдлаар Засаг дарга болон ЗДТГ-т нийт 528 өргөдөл ирсэнээс 518 өргөдөл хугацаандаа шийдвэрлэгдэж, 10 өргөдөл шийдвэрлэгдэх шатандаа байна.	100
17	Иргэдийн өргөдөл, гомдол, хүсэлт, мэдээллийн шийдвэрлэлтийн талаар байгууллагын вэб сайтад тогтмол мэдээлж хэвших	Иргэдийн өргөдөл, гомдол, хүсэлт, мэдээллийн шийдвэрлэлтийн талаар байгууллагын вэб сайтад тогтмол мэдээлж хэвших	Улирал бүр	Өргөдөл гомдол, санал, хүсэлтийн мэдээллийг shiveegovi.gov.mn цахим хуудаст улирал бүр байршуулан ажилласан.	100
Биелэлтийн дундаж хувь					98,2

ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР